

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ДЭД БҮТЦИЙГ  
ХОГЖУУЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ  
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

ГЭРЭЭНИЙ ДУГААР .....

2023 он

Алтай хот

Сумын Засаг дарга .....

Тусгай зөвшөөрөл эзэмшигч .....



**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХТУХАЙ  
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

2023 оны ..... сарын .... өдөр

Дугаар.....

Алтай хот

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг дарга Д.Наранбадрах (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас XV-018305 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Боролзой” ХХК (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү Гэрээг байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү гэрээ нь Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах асуудлаар хамтран ажиллахад талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь XV-018305 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орших газрын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих талаар сайн дурын үндсэн дээр дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

1.3. Гэрээг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн 2024 оны ..... сарын .....-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байгуулав.

**ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр хангах, хуульд заасан дэмжлэгийг үзүүлэх;

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд сум орон нутаг, төрийн байгууллагын албан хаагчид болон иргэдийн зүгээс хууль бус дарамт шахалт үзүүлэх асуудлыг таслан зогсоох, буруутай этгээдэд хариуцлага тооцох;

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

2.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах (байгаль орчны нөхөн сэргээлтийг чанартай хийх, усны зөв хэрэглээ, төлбөр хураамжийг хуулийн дагуу төсөвт төвлөрүүлэх, ажиллах хүчний талаар);

2.7. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамтран хэрэгжүүлэх санал тавих

2.8. Энэхүү гэрээний дагуу хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар баг, сумын иргэд, байгууллагуудад сурталчилах, мэдээлэл хийх;

2.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээнд тусгагдаагүй зүйл шаардахгүй байх /тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээс бусад/


2.10. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах.

**ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн

Сумын Засаг дарга .....

Тусгай зөвшөөрөл эзэмшигч.....



**иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр:**

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.3. Байгаль орчныг хамгаалах менежментийг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.1.4. Засаг даргын санал болгосон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутаг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас харилцан зөвшилцөж, сонгон хэрэгжүүлэх;

3.1.5. Хамтран хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, санал тавих;

3.1.6. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар аймаг, сумын иргэдэд мэдээлэл өгч, сурталчилах;

3.1.7. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд эхний ээлжинд давуу эрх олгох;

3.1.8. Орон нутгийн оюутан залуусыг дадлага хийх нөхцөл боломжоор хангаж, Хөдөлмөрийн тухай хуульд заасан гэрээ байгуулж, цалин хөлс олгох;

3.1.9. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.1.10. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;

3.1.11. Хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

**3.2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр:**

3.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2.3. Орон нутгийн төсөвт төлөх татвар, хураамж, төлбөрийг холбогдох хуулийн дагуу хуульд заасан хугацаанд бүрэн төвлөрүүлэх;

**3.3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр:**

3.3.1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хуульд заасны дагуу тайлагнах;

3.3.2. Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайланд хяналт тавьж ажиллах;

**ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТ, ТАЙЛАГНАЛТ**

4.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

4.2. Гэрээний биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

**ТАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА**


5.1. Энэхүү гэрээ нь талуудыг хууль тогтоомжид заасан бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.2. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хүчтэй салхи,

Сумын Засаг дарга .....

Тусгай зөвшөөрөл эзэмшигч .....



шуурга, халдварт өвчин, байгалийн бусад аюулт үзэгдэл, хатуу хөл хорио, төрийн оролцоо)-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдсэнээр харууцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно. Дээрх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тус нөхцөл байдал арилах хүртэлх хугацаагаар харилцан тохиролцож хойшлуулж, сунгана.

5.4. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

6.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

**ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

7.1. Талууд гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

7.3. Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэв. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг Англи хэл дээр үйлдэж болно.


7.4. Энэхүү гэрээ нь .... хуудас хавсралттай болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТӨЛӨӨЛЖ:**  
**ХӨХМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГА**  
 ..... (Д.Наранбадрах)  
 (гарын үсэг, тамга) (гарын үсгийн тайлал)  
 Хаяг, байршил: Монгол Улс, Говь-Алтай аймаг, Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар  
 Регистрийн дугаар: .....  
 Утас: .....  
 И-мэйл: .....

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**  
**"БОРОДЗОЙ" ХХ-ийн захирал**  
 ..... (Д.Батбаяр)  
 (гарын үсэг, тамга) (гарын үсгийн тайлал)  
 Хаяг, байршил: Улаанбаатар хот, БЗД, 1 дүгээр хороо, Их тойруу-93  
 Регистрийн дугаар: 2085976  
 Утас: 99114682  
 И-мэйл: batyi1911@gmail.com

Сумын Засаг дарга .....

Тусгай зөвшөөрөл эзэмшигч .....  


Байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг  
хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай  
“Боролзой” ХХК-тай байгуулсан  
нийгмийн хариуцлагын гэрээний хавсралт

ХӨХМОРЬТ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХТАЙ  
ХОЛБОГДСОН АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ, ОРОН НУТГИЙН  
ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

2023 оны ..... сарын .... өдөр

Алтай хот

Гэрээний дугаар .....

Гэрээ байгуулсан талууд: Говь-Алтай аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг дарга Д.Наранбадрах, нөгөө талаас ашигт малтмалын XV-018305 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч “Боролзой” ХХК

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө, дэмжлэг, хандив, тусламж
Нэг. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр			
Хоёр. Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр			
	Ажлын байр	9-10 сар	2,000,000₮

\_\_ооо\_\_

Сумын Засаг дарга .....

Тусгай зөвшөөрөл эзэмшигч .....